

Мэдээлэл, Холбооны Технологи Боловсролд

М.Мөнхбаатар^{#1}, О.Дүнжиннамдаг^{#2}

^{#1} БСШУСЯ -ны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

^{#2} БСШУСЯ -ны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Хураангуй— Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хувьд МХТ-ийг боловсролын салбарт, түүний дотор ерөнхий боловсролын түвшинд нэвтрүүлэх асуудал ямагт анхаарлын төвт байсан бөгөөд сургуулиудын сургалтын очныг мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн тусламжтай бүрдүүлэх, агуулга, чанарыг сайжруулах чиглэлээр олон тооны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Сүүлийн жилүүдэд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнд орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудад интернэт үйлчигээ хүргэх 21 аймгийн төвийг Улаанбаатар хоттой холбосон боловсролын төрөлжсөн томоохон сүлжээний үндэс тавигдаж байна. Энэ сүлжээг зөвхөн харицаа холбооны асуудал биш, тэр сүлжээн дээр суурилсан удирдлага мэдээллийн систем, цахим агуулга зэргийг багтаасан цогц шийдэл шийдэл гэж ойлгох хэрэгтэй. Боловсролын салбарт МХТ-ийг нэвтрүүлэх асуудал нь өөрөө олон талт, нийлмэл процессийн хувьд төр, бизнес, судалгааны байгууллагын идэвхитэй хамтын ажиллагаа, оролцоог шаарддаг.

Түлхүүр үг: Мэдээлэл, холбооны технологи; Боловсрол

I. УДИРТГАЛ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хувьд МХТ-ийг боловсролын салбарт, түүний дотор ерөнхий боловсролын түвшинд нэвтрүүлэх асуудал ямагт анхаарлын төвт байсан бөгөөд сургуулиудын сургалтын очныг мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн тусламжтай бүрдүүлэх, агуулга, чанарыг сайжруулах чиглэлээр олон тооны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэн эхний жилүүдэд бодлогын хомсдол, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төслийн удирдлагын туршлага зэргээс хамаарч хоорондоо уялдаа холбоо муутай, нэгдсэн бодлогогүй олон тооны төсөл хэрэгжсэн нь үнэн. Тэгвэл сүүлийн жилүүдэд боловсролын салбарт МХТ-ийг нэвтрүүлэх ажил илүү цогц, нэгдмэл шинжтэй болж, тэр нь салбарын хэмжээний нэгдсэн сүлжээ бүхий мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, програм хангамжийн шийдэлтэй болон хөгжиж байна. Сүүлийн жилүүдэд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төслүүдийн үр дүнд орон нутгийн ерөнхий боловсролын сургуулиудад интернэт үйлчигээ хүргэх 21 аймгийн төвийг Улаанбаатар хоттой холбосон боловсролын төрөлжсөн томоохон сүлжээний үндэс тавигдаж байна. Одоо МХС ТӨК-ий суурь дэд бүтэц дээр суурилсан энэ сүлжээнд 247 сумын 255 ЕБС, 21 аймгийн төв, Улаанбаатар хотын алслагдсан 2 дүүргийн 200 гариу ЕБС холбогдож, интернэтийн болон бусад үйлчилгээг авч байна.

Цаашдаа энэ сүлжээнд бүх шатны боловсролын байгууллагыг үе шаттай холбох бодлого баримтлана.

Боловсролын салбарт МХТ-ийг нэвтрүүлэх дэд бүтцээс дутуугүй ач холбогдолтой асуудал нь боловсролын агуулга, технологийг хөгжүүлэх, энэ салбарын мэргэжилтний мэдлэг, ур чадвар, өрсөлдөх чанарыг дээшлүүлэх явдал юм. Энэ чиглэлээр одоо хэрэгжиж байгаа зарим төслийг дурьдвал:

- “Шинэ зууны боловсрол”, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл
- “МХТ-ийн аутсорсингийн төв”, БНЭУ-ын хөнгөлөлттэй зээл
- “Ухаалаг боловсрол төсөл”, БНСУ-ын хөнгөлөлттэй зээл

II. БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖСЭН ЗАРИМ ТӨСӨЛ

A. Боловсролын Салбарын Мэдээллийн Сүлжээ

2008 оноос төрийн болон орон нутгийн хөрөнгө, төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, боловсролын байгууллагуудыг шилэн кабелиар холбооны дэд бүтэцэд холбож байсан ажлыг үрэгжүүлэн боловсролын салбарын өргөн зурвасын нэгдсэн сүлжээ байгуулах зорилт тавин ажиллаж одоогийн байдлаар Улаанбаатар хотын 37, 21 аймгийн 200, 247 сумын төвийн 255 ерөнхий боловсролын сургуулийн шилэн кабелиар холбооны дэд бүтэцтэй холбон интернэт үйлчилгээг хүргэж байна.

Боловсролын дата төв байгуулах, Эрдэмнэт сүлжээний төвийн өргөтгөл хийх ажлыг 2012 оноос эхлүүлэн Улсын төсөв болон Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтээр 2013 онд 1,5 тэрбум, 2014 онд 953 сая, 2015 онд 1,4 төгрөгийн санхүүжилт нийт 3,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж сервер, тоног төхөөрөмж, сүлжээний нөөц эх үүсвэр худалдан авч суурилуулан ажиллаж байна.

Боловсролын дата төвд тулгуурлан Шинэ зууны боловсрол төслийн хүрээнд боловсролын нэгдсэн сүлжээний төв байгуулах ажлыг 2016 онд хийж гүйцэтгэсэн.

B. Сургалтын Цахим Хэрэглэгдэхүүн, Цахим Объект

Сургалтын цахим хэрэглэгдэхүүнээр хангах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө орууллагаар 2014 онд 2,4 тэрбум, 2015 онд 400 сая төгрөгийн үнийн дүнтэй нийт 350 иж бүрэн ухаалаг самбар, тоон үзэг, проекторын иж бүрдэл хүлээн авч аймаг, нийслэлийн 65 ерөнхий боловсролын сургуульд суурилуулан сургалтад ашиглаж эхлүүлээ.

2014 онд Азийн хөгжлийн банкны "Боловсролын салбарын шинэчлэл төсөл" -ийн санхүүжилтээр 8-12 дугаар ангийн байгалийн ухааны хичээлийн 144 сургалтын цахим объектын боловсруулсан ба Азийн хөгжлийн банкны "Санхүүгийн хямралын үед нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үлчилгээ хүргэх төсөл" -ийн санхүүжилтээр ерөнхий боловсролын сургагчдад ашиглагдаж байгаа 168 сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүллээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам 2014 оноос эхлэн Нээлттэй мэдлэг, боловсролын сантай хамтран Дэлхий даяар хамгийн өндөр хандалт, ашиглалттай, үнэ төлбөргүй, онлайн, нээлттэй сургалтын үйлчилгээ болох АНУ-ын Хан академийн ерөнхий боловсролын сургалтын математик, биологи, мэдээллийн технологи, түүх, физикийн 800 видео хичээлийг орчуулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид нээлттэй, үнэ төлбөргүй ашиглах боломжийг бий болгохоор гэрээ байгуулан хамтран ажиллаж 2014 онд 500, 2015 онд 300 цахим хичээлийг хөрвүүлэн "mn.khanacademy.org" цахим хуудсанд байрлуулж, нийтийн хүртээл болгож холбогдох сургалтуудыг зохион байгууллаа.

III. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

2014 оноос Улсын төсөв болон Азийн хөгжлийн банкны Боловсролын салбарын шинэчлэл төслийн хүрээнд Боловсролын салбарын мэдээллийн системийн үндсэн платформ, системийн модуль, хүний нөөц, статистик модулиудыг боловсрууллаа.

A. Мэдээллийн Системийн Үндсэн Суурь

Системийн хөгжүүлэлтийг Oracle JDeveloper 12c програмд тулгуурлан хийсэн бөгөөд хөгжүүлэлтийн явцыг удаашруулах механик ажиллагаа болон хөгжүүлэгчийн гаргаж болзошгүй механик алдааг багасгах зорилгоор JDeveloper 12c дээр хөгжүүлж буй системд зориулагдсан ESIS системийн суурь модулийн роль, ESIS системийн Хүний нөөц, Боловсрол, Статистик, Санхүү болон Асуулгын системийн хөгжүүлэлтийн роль үүсгэж, тус бүрт нь зориулан суурь модулийг хөгжүүлсэн.

Бүх модулийн Business model түшинд ашиглагдах bundle, баазын орчуулга, database user session, системийн хэл болон бусад системийн үндсэн ажиллагаатай холбоотой суурь, Application Module, Entity болон View object-тэй холбоотой суурь, User Interface түвшинд ашиглагдах bundle, интерфейс түвшний хэлний орчуулга, Хүний нөөц, Боловсрол, Статистик, Санхүү болон бусад модулиудын нэгтгэл, Skin, Template, Converters, загвар солих, системийн нууцлал болон Java utilities-тай холбоотой сууриудыг тус тус бэлтгэн тохируулсан.

B. Системийн Нууцлал

Oracle Real Application Security нь Oracle Platform Security Service-тэй ажиллаж хэрэглэгч, эрх болон нууцлалыг удирдах суурь юм. Системийн баазын түвшний нууцлалыг Oracle Real Application Security технологид тулгуурлан зохион байгуулсан. Одоогоор ашиглагдаж байгаа Хүний нөөц, Боловсрол, Статистик, Санхүү, Асуулга болон бусад

системүүдийн хүрээнд 1,050 орчим баазын роль, 37,400 орчим хэрэглэгч, 13 төрлийн 1,350 орчим нууцлалын профайлыг үүсгэсэн бөгөөд эдгээрийн бүтэц болон суурь хэсэг хийгдсэн.

Нэвтэрсэн хэрэглэгчийн системд нэвтрэх үеийн ажлын харилцаа, тохиргооны мэдээлэл болон хэрэглэгчийн баазын рольтой холбоотой мэдээллүүдийг session-д бэлтгэх суурь бэлдсэн.

Интерфейс түвшинд Oracle Platform Security Service технологийг ашигласан. Одоогийн байдлаар 23 Application role, 290 орчим resource, 82 орчим Entitlement үүсгэсэн. Oracle Internet Directory сервер дээр 37,400 орчим хэрэглэгч, 1,300 орчим роль менежмент хийгдсэн байна.

C. Хүний Нөөцийн Дэд Систем

Байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хялбараар удирдах, ажилтан ажилд орсноос халагдах хүртэлх процессыг хөтлөн явуулах, ажилтан, менежерүүдэд оновчтой шийдвэр гаргахад туслах үүрэг бүхий систем юм.

Эдгээр байгууллагын бүтцийн өөрчлөлт, орон тооны хөдөлгөөн, цалин хөлсний өөрчлөлт, ажилтны шилжилт хөдөлгөөнийг боловсролын салбарын хэмжээнд тасралтгүй хөтлөн явуулах, хянах боломжтой боллоо.

Хүний нөөцийн системийг боловсролын салбарын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн бүх ерөнхий боловсролын сургуульд нэвтрүүлсэн. Нийт 768 сургуулийн 25,975 ажлын байран дээр ажиллаж байгаа 54,680 багш ажилчдын цалин хөлс, ажлын түүх, боловсролын мэдээлэл бүрдсэн.

D. Боловсролын Удирдлагын Дэд Систем

Боловсролын байгууллагын сургалтын үйл явцыг оновчтой удирдах, элсэлтээс төгсөлт хүртэлх бүхий л үйл ажиллагааг хөтлөн явуулах зорилготой дэд систем юм. Өнөөдрийн байдлаар төр, хувийн хэвшлийн бүх ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчин, сургалтын бүтэц, сургалтын хөтөлбөр, хичээл, суралцагч, багш, анги бүлэг, хичээлийн хуваарь, шилжилт хөдөлгөөн, сурагчийн өдөр тутмын үйл ажиллагааг хөтлөн явуулж байна. Эдгээр сургуулиуд дээр явагдаж буй сургалтын үйл ажиллагааг хөтлөн явуулах явцад 768 сургууль, 1,512 хичээлийн байр, 987 дотуур байр, 21,392 бүлэг, 545,172 сурагч, 30,085 багш, 19,531 ажилтан, 2,662 бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн мэдээлэл бүрдсэн байна.

E. Үндсэн Хөрөнгийн Бүртгэлийн Дэд Систем

Боловсролын байгууллагын санхүүгийн удирдлагын дэд системийн үндсэн хөрөнгийн бүртгэл, хөрөнгө хуваарилалтын хэсгийг боловсруулж, компьютер, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн бүртгэл хийгдсэн.

F. Агуулгын Удирдлагын Систем

Хүний нөөц, боловсрол, санхүү, статистик зэрэг системд ашиглагдаж буй файл, цахим агуулгыг хадгалах, удирдах, share хийх зэрэг үйл ажиллагааг удирдах агуулгын менежментийн системийг тохируулан ашиглаж эхэлсэн.

Г. Суралцахуйн Удирдлагын Систем

Суралцахуйн мэдээллийн системийн бизнес процессийн шинжилгээ, системийн шинжилгээг хийж дуусгасан. Багшийн хөгжлийн модулийн програмын хөгжүүлэлтийг хийж, улсын хэмжээнд 30,085 багшийн мэргэжлийн хөгжлийн мэдээллийг цуглуулан БМДИ-ийн үйл ажиллагаанд ашиглах боломжоор хангасан.

Н. Боловсролын Салбарын Портал

Мэдээллийн системийн танилцуулга, гарын авлага, видео хичээл болон бусад төрлийн мэдээллийг нэгтгэн хэрэглэгчдэд харуулах зорилго бүхий Боловсролын салбарын мэдээллийн системийн порталыг боловсруулсан. Өдөр бүр 5000 хэрэглэгч хандаж байна.

- Боловсролын салбарын хүний нөөц, боловсрол, санхүүгийн өдөр тутмын системээс статистик мэдээллийг татаж, мэдээллийн агуулахад байршуулан мэдээлэл шинжилгээний системээр дамжуулан олон нийтэд Статистикийн портал хэлбэрээр хүргэж байна.
- 1-12 ангийн 300 гаруй сурах бичгийг онлайн хэлбэрээр хүргэх, 144 иконтентийг Цахим контентийн портал хэлбэрээр байршуулан багш, сурагч, эцэг эх, олон нийтэд хүргэж байна.

И. Боловсролын Салбарын Портал

Мэдээллийн системийн танилцуулга, гарын авлага, видео хичээл болон бусад төрлийн мэдээллийг нэгтгэн хэрэглэгчдэд харуулах зорилго бүхий Боловсролын салбарын мэдээллийн системийн порталыг боловсруулсан. Өдөр бүр 5000 хэрэглэгч хандаж байна.

- Боловсролын салбарын хүний нөөц, боловсрол, санхүүгийн өдөр тутмын системээс статистик мэдээллийг татаж, мэдээллийн агуулахад байршуулан мэдээлэл шинжилгээний системээр дамжуулан олон нийтэд Статистикийн портал хэлбэрээр хүргэж байна.
- 1-12 ангийн 300 гаруй сурах бичгийг онлайн хэлбэрээр хүргэх, 144 иконтентийг Цахим контентийн портал хэлбэрээр байршуулан багш, сурагч, эцэг эх, олон нийтэд хүргэж байна.

Ж. Харилцааны Менежментийн Систем

Харилцааны систем нь хэрэглэгч хоорондын харилцааг хялбарчлах, мэдээллийг найдвартай, түргэн, шуурхай солилцох бололцоог бий болгох зорилго бөгөөд чат, и-мэйлийн системийг боловсруулж, нэвтрүүлэхэд бэлэн болсон.

К. Асуулгын Удирдлагын Дэд Систем

Боловсролын салбарын суурь мэдээллийг богино хугацаанд, үнэн зөв цуглуулах, шийдвэр гаргагчдыг оновчтой шийдвэр гаргах бодит мэдээллээр хангах зорилгоор динамик асуулга зохиох, асуулга тархах, мэдээлэл цуглуулах үүрэг бүхий асуулгын удирдлагын системийг боловсруулж нэвтрүүлсэн.

2014-2015 хичээлийн жилд

- Ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвөөс Байгууллага, Сургалтын орчин, Номын сан, Санхүү, Багш, Ажилтан, Удирдах нийгмийн ажилтан, Сурагчийн мэдээлэл, Боловсрол соёлын байгууллагаас Ажилтны мэдээлэл, Их дээд сургуулиас Байгууллага, Багш ажилчид, Шинэ элсэлт, Оюутны мэдээллийг тус тус Асуулгын удирдлагын систем ашиглан суурь мэдээлэл болгон цуглуулсан.

2015-2016 оны хичээлийн жилд

- Их, дээд сургуулийн шинэ элсэлтийн мэдээллийг Боловсролын үнэлгээний төвийн мэдээлэлтэй тулган цуглуулсан. Мөн Их, дээд сургуулийн элсэлтийн үнэн зөв мэдээллээр Төрийн санг хангах ажлыг гүйцэтгэсэн.

Л. Статистикийн Удирдлагын Мэдээллийн Систем

Асуулгын удирдлагын систем, Хүний нөөцийн систем, Боловсролын удирдлагын систем, Хөрөнгийн удирдлагын системээс мэдээллийг тодорхойлсон хугацаанд автоматаар татан тайлан, нэгтгэл мэдээллийг боловсруулдаг. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, боловсрол соёлын газар, БСШУЯамны нийт 1000 орчим байгууллагын албан хэрэгцээний Статистикийн системийг ашиглан 80 гаруй тайлан, нэгтгэлийн мэдээллийг боловсруулан гаргаж байна.

М. Мэдээллийн агуулах, Мэдээллийн Шинжилгээний Систем

Өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг түүхчилсэн болон бусад хэлбэрээр хадгалж, тухайн мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийх зориулалттай систем юм. Энэ системийг ашиглан Боловсролын салбарын 6 бүлэг бүхий 150 орчим хянах самбар, индикатор, мөн олон улсын түвшинд Монгол улсын боловсролын чанарын үзүүлэлтийг харуулах Юнескогийн 100 орчим индикаторыг боловсруулан гаргаж байна.

Н. Боловсролын Салбарын Лавлах Сан

62 их, дээд сургуулийг 2000-2015 онуудад төгссөн 137,891 төгсөгчийн цахим лавлах сан бүрдүүлэн мэдээллийн системд оруулж, лавлагааны системийг боловсруулсан.

2013, 2014, 2015 оны суурь боловсролын 153,613, бүрэн дунд боловсролын 95,079 төгсөгчийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлсэн. Дээрх бүрдүүлсэн цахим лавлах санд тулгуурлан хариуцсан нэгжээс лавлагааны системээр дамжуулан түргэн шуурхай лавлагаа гаргах боломжтой болсон.

IV. Одоо Хэрэгжүүлж Буй Төсөл, Хөтөлбөр

А. Мэдээллийн Технологийн Боловсрол болон Аутсорсингийн Төв Төсөл

Төслийн зорилго нь олон улсын түвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилгоор олон

улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийг байгуулж Монгол Улсын экспортыг дэмжих юм.

Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт-Импорт банкны хооронд 2012 оны 2 сарын 14-ны өдөр 20.0 сая ам.долларын гэрээг байгуулсан. “Монгол-Энэтхэгийн хамтарсан Мэдээлэл технологийн боловсрол, Аутсорсингийн төвийн барилга, байгууламж” (МЭХМТ) төслийг Монгол-Энэтхэгийн Засгийн газрын хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа болно.

В. Шинэ Зууны Боловсрол Төсөл

Төслийн зорилго нь боловсролын салбарын мэдээллийн системийн үндсэн дэд бүтэц байгуулж, түүн дээр суурилсан электрон сурах орчныг бүрдүүлэн хүүхэд бүрд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмшүүлэхэд оршино.

Үр дүн 1: Багш, сурагч бүр мэдээллэлийг эрх тэгш хүртээмжтэй авна.

Үр дүн 2: Хот болон хөдөөгийн багш, сурагчийн мэдээллийн хоцрогдол арилна.

Үр дүн 3: Дэлхийн жишигт нийцсэн мэдээлэл технологийн сургалтын бааз, ном, сурах бичгээр хангагдан, сургалтын чанарт ахиц гарна.

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 285 дугаар тушаалаар байгуулагдаж БНХАУ-ын компаниуд дунд нээлттэй тендер зохион байгуулсан. Энэхүү тендерт БНХАУ-ын ZTE корпораци шалгаран 2013 оны 03 дугаар сарын 26 -нд НС-01/2012 тоот гэрээ байгуулсан. Гэрээний нийт үнийн дүн **45,673,586** ам.доллар.

Төслийг боловсруулж эхлэх хугацаанаас хойш гэрээнд дараахь шалтгаанаар хоёр удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүнд:

- 2014 он хүртэл тоног төхөөрөмж, зөөврийн компьютерийн үзүүлэлт сайжирч, үнэ буурсан гэдэг шалтгаанаар 2014 оны 05 дугаар сарын 28-нд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан
- “ZTE” корпорацийн сүлжээний төхөөрөмжийн дараагийн хувилбар гарсан гэдэг шалтгаанаар 2015 оны 09 дүгээр сарын 22-нд нэмэлт гэрээ байгуулсан.

Гэрээний үргэлжлэх хугацаа 1 жил 6 сар.

С. Ухаалаг Боловсрол Төсөл

Төслийн зорилго нь уламжлалт сурах бичигтэй хослуулан төрөл бүрийн мультимедиа, интерактив контент ашиглах, анги танхимд багш төвтэй сургалт явагдах, мэдээллийн технологиид суурилсан сургалтад үе шаттай шилжих боломж бүрдэхэд оршино.

“Ухаалаг боловсрол” төслийг хэрэгжүүлэхээр 2016 оны 5 дугаар сарын 27 –ны өдөр БНСУ-ны талаас Экзим банкны төлөөлөл, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн **19,609,000** ам.доллар.

Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний компани болон үндсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/28 дугаар тушаалаар, төслийн бэлтгэл ажлыг хангах, шалгарсан зөвлөх үйлчилгээний компанитай хамтран ажиллах, хяналт тавих ажлын хэсэг Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/129 дугаар тушаалаар тус тус байгуулагдан ажиллаж байна. Үнэлгээний хороо Зөвлөх үйлчилгээний компанийн ажлын даалгаварыг боловсруулж БНСУ-ын Экзим банкинд 2017 оны 4 дүгээр сарын 05 –ны өдөр санал авахаар хүргүүлээд байна.

V. Дүгнэлт

Боловсролын салбарт МХТ-ийг нэвтрүүлэх асуудал нь өөрөө олон талт, нийлмэл процессийн хувьд төр, бизнес, судалгааны байгууллагын идэвхитэй хамтын ажиллагаа, оролцоог шаарддаг.

МХТ-ийн эрчимтэй хөгжил нь өөрөө судлагдахуун болохоос гадна хүмүүний амьдрал, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хөгжлийн гол хурдасгуур болдог. Ялангуяа боловсролын салбарт МХТ-ийг бүхий л чиглэлээр нэвтрүүлснээр боловсрол, сургалтын талаар өнөө хир тогтсон уламжлалт ойлголт, арга барилыг шинэ хандлага, технологиор баяжуулж, баялаг агуулга, хүртээмж, нээлттэй, сонголттой бйадлыг бий болгодог.

Судлаачдын хувьд энэ бол дундаршгүй арвин сэдэв бөгөөд БСШУСЯ энэ чиглэлийн санал, санаачлагыг ямагт дэмжин ажиллах болно.